

Соёлын тухай ойлголтын зарим асуудалд

On some issues of the concept of culture

Лувсандамбын Дашням¹

Доктор (Ph.D), профессор
ludash315@yahoo.com

Dashnyam Luvsandamba

Doctor (Ph.D), professor
ludash315@yahoo.com

Хураангуй:

Соёл гэдгийг бид орчлон ертөнцөд хор хөнөөл үгүй, хүний амьдралыг бусниулж сөнөөхгүй тийм дэвшилтэт сайныг бий болгон, түүнээ өсгөж үржүүлж буй үргэлжидийн үйл явц, түүний бүтээгч үр дүн гэж ойлгодог. Өөрөөр хэлбэл, хүн, нийгмийг бүтээдэг гол хүчин зүйл маань соёл мөн.

Гэтэл өнөөдөр бидний бүтээсэн соёл, тэрчлэн соёлт хүн маань нийгмийн олон талт үйл явц, амьдралын бэрхшээл зөрчил, байгаль экологийн томоохон сүйрлийн өмнө тулж ирсэн нь тодорхой болж байна.

Иймд өнөөгийн нөхцөлд соёлт хүнийхээ тухай ч, түүний бүтээн цогцлоож байгаа соёлуудын тухай ч ярьж хэлэлцэх, санаж сэрэх, өөрчлөх юм бидэнд багагүй байгаа нь өдөр ирэх тусам мэдрэгдсээр байгаа юм.

Түлхүүр үгс: соёл, дэлхийжил, нөхцөлдөөнт бус үйлчлэл, соёлт ертөнц

Abstract:

We understand culture as a continuous process of creating and growing good things in the universe that do not harm and destroy human life, and its creative results. In other words, culture is the main factor that creates people and society.

However, today it is becoming clear that the culture we have created, as well as our cultured people, have been faced with multifaceted social processes, life's difficulties and conflicts, and major ecological destruction.

Therefore, in the current situation, we feel that we have a lot to talk about, remember, and change about our cultured man and the cultures he creates.

Keywords: culture, global, unconditional service, civilized world

I. Оршил

Дэлхийжлийн үйл явц өргөн хүрээнд эрчимтэй явагдаж байгаа өнөөгийн нөхцөлд төрөл бүрийн соёлын харилцаа холбоо, эерэг болон эерэг бус элдэв нөлөөлөл, нөхцөлдөөнт хийгээд нөхцөлдөөнт бус үйлчлэл мэдрэгдэхүйц нэмэгдсээр байна. Бие биенээ хөгжүүлж цэцэглүүлж байгаа ч зүйл байна, бас хөшөөж царцааж, тэр байтугаа хөнөөх үйл явц ч ажиглагдах боллоо. Нэг үгээр урагшилж, ахиж, дэвшиж дэвшиж байгаа ч юм байна, ухарч буцан, мөхөл

¹ © Зохиогч. 2022. Сэтгүүлд нийтлэгдсэн эрдэм шинжилгээний бүтээл нь зохиогчийн оюуны өмч байх бөгөөд (CC BY- <https://creativecommons.org/licenses/by/4.0/>) нөхцөлийн хүрээнд ашиглана уу.

рүүгээ явж байгаа ч юм байна. Ийм нөхцөлд соёлын оршил, орчлын тухай ахин дахин ярих нь амьдралаас аяндаа урган гарч байгаа бодот зүйл гэж үзэлтэй.

Юуны өмнө соёлыг бүтээж байгаа хүний өөрийнх нь тухай ярих нь зүйтэй. Тийм шаардлага улам бүр нэмэгдсээр байна. Хүний бүтээж бий болгож буйг эзэнгүйгээр ойлгох ямар ч боломжгүй учир тэр нь зайлшгүй гэдэг нь ойлгомжтой.

II. Судалгааны арга зүй

Соёл бол хүмүүн бидний түүхэн бүтээл! Хүмүүн төрөлтөн соёлт хүнийг бүтээж, соёлт амьдралыг цогцлоож, соёлт нийгмийг байгуулж ирсэн түүхтэй. Түүгээрээ ч амьдралыг цогцлоож, түүхийг бүтээгч хэмээн цоллуулдаг. Гэвч бүтээж байгаа Эзнийг нь ч, бий болгож цогцлоож буй соёлыг нь ч эдүгээ бид эргэн харж "энэ юу гээч болж байна вэ?" гэж асуух шалтаг, шалтгаан өдрөөс өдөрт нэмэгдсээр байгааг нуух хэрэггүй. Соёлт амьдралыг бид цогцлоож чадаж байна уу? гэж асуумаар бодот байдал нэмэгдсээр л байна. Ерөнхий байдлыг ажиглавал:

- 1. Соёлын тухай ойлголт дэлхий дахинд улам бүр нийтлэг болж, нийтлэг нэгэн соёлтой байхыг хүсэж эрмэлзэх нь нэмэгдсээр байна.*
- 2. Том том соёлын нөлөөнд уламжлалт соёл нь өртөх явдал нийтлэг үзэгдэл болж, тэгснээр зарим нэг унаган соёл мөхөл рүүгээ явж байгаа, мөхөж устаж ч байгаа нь ажиглагдаж байна.*
- 3. Соёлыг бүтээгч Эзэн - хүн өөрөө өөрчлөлтийн их шуурганд нэрвэгдэн, соёлт хүн биш болж хувирч байна. Юутай ч соёлын мөргөлдөөн үргэлжилсээр байгаа юм.*

Үүний үр дүнд Европ соёл дэлхийд өргөнөөр түгж, европ маягаар амьдрахыг эрмэлзэгчид өдөр ирэх тусам нэмэгдэж байгаа нэг үзэгдэл, нөгөө талаар уламжлалт соёлын үнэ цэнэ улам бүр мэдрэгдэх болж, түүнийг талархан таашаагчид ч өсөж үржсээр байгаа нь соёлт ертөнцийн ерөнхий дүр төрх болж байна. Үүнтэй зэрэгцээд энэ тэр соёл гэхээсээ илүү өөрийнхөөрөө амьдрахыг хүсэгчдийн тоо ч олшрух болсон сонин үзэгдэл ч бий болсоор байгаа юм.

III. Судалгааны үр дүн, хэлэлцүүлэг

Соёл гэдэг үгийг хүмүүн төрөлтөн анх зэрлэг ургамлыг тарималжуулахтай л холбоотой ойлгож ухаарч ирснийг бид мэднэ. НТӨ 160 жилийн орчим Марк Порций Катон (Marcus Porcius Cato /НТӨ 234-149/) гэдэг хүн "Газар тариалан" нэртэй бүтээлдээ анх cultura гэдэг үгийг дурьдсан гэж үздэг[1]. Түүнээс хойш 2182 жил өнгөрчээ. Хүний удам угсаа 80 гаруй удаа солигдож улирч өөрчлөгджээ гэсэн үг болно. Энэ их урт удаан хугацааны туршид бид соёлыг хүн төрөлхтний түүхэн бүтээсэн аугаа их өв хэмээн үзэж, тэр бүхнийг амьдралыг цогцлоогч хүнд, хүний бүтээл туурвилд, нийгмийн бүтээн байгуулалтад хамаатуулан авч үздэг, хүнийг хүмүүжүүлэх, боловсруулах, хөгжүүлэх, хүндэтгэж хайрлах талаар тасралтгүй ярьсаар ирсэн байна. Энэ хугацаанд соёлын тухай ойлголт ч, түүний судалгаа ч асар их хөгжсөн. Нэг үгээр хүн өөрийгөө ч, соёлоо ч бүтээсэн байна.

Америкийн антропологич Лейсли Уайт 1959 онд бичсэн "Соёлын хувьсал" нэртэй бүтээлдээ соёлсудлал нийгмийн ухаанаас өрх тусгаарлах боломжтой

байгааг анхааруулж, энэ асуудлыг анх түрүүн хөндөж тавьсан гэж үздэг. Бас л жаран илүү болсон байна[2].

Соёл судлал энэ салбарын ойлголт ухааралыг гүнзгийрүүлж, нийгэм, ахуй амьдрал, урлаг, урансайхны өргөн хүрээний үзэгдэл юмс, амьдралын өргөн хүрээний асуудлыг авч үздэг боловч хүний мөн чанар, хүмүүн харилцааны соёлын талаар онцгойлон анхаарахын хувьд дутагдалтай байгааг ярих учиртай. Бидний дээдлэн шүтдэг үлгэрлэлт соёлын эзлэн түрэмгийлэл, давамгайллын талаар ч үг хэлэх цаг болсон. Эдүгээ нарийндаа соёлыг хардаг, ойлгож ухаардаг нэг л үзэл ноёлж байна. Европ соёл л соёл соёлын дээд гэж үзэх болсон нь худлаа ч биш юм. Хөгжилтэй орнууд соёлтой, хөгжиж буй болон ядуу буурай орнууд соёлгүй, бүдүүүлэг гэдэг нийтлэг үзэл ч байсаар л байгааг ч хэлэх учиртай.

Соёл гэдгийг бид орчлон ертөнцөд хор хөнөөл үгүй, хүний амьдралыг бусниулж сөнөөхгүй тийм дэвшилтэт сайныг бий болгон, түүнээ өсгөж үржүүлж буй үргэлжидийн үйл явц, түүний бүтээгч үр дүн гэж ойлгодог. Өөрөөр хэлбэл, хүн, нийгмийг бүтээдэг гол хүчин зүйл маань соёл мөн. Гэтэл өнөөдөр бидний бүтээсэн соёл, тэрчлэн соёлт хүн маань нийгмийн олон талт үйл явц, амьдралын бэрхшээл зөрчил, байгаль экологийн томоохон сүйрлийн өмнө тулж ирсэн нь тодорхой болж байна. Иймд өнөөгийн нөхцөлд соёлт хүнийхээ тухай ч, түүний бүтээн цогцлоож байгаа соёлуудын тухай ч ярьж хэлэлцэх, санаж сэрэх, өөрчлөх юм бидэнд багагүй байгаа нь өдөр ирэх тусам мэдрэгдсээр байгаа юм.

Соёлыг бид хүн болоод хүний амьдралд хамаатуулан ойлгож, юуны өмнө хүнийг өсгөж, горниулах, цаашлаад сургаж соёх, хүмүүнжүүлэх гэж ойлгож ухаарч ирсэн[3].

Хүнийг хүмүүнжүүлэх, боловсруулах өргөн цар хүрээт ажлаа хамгийн үнэ цэнтэй соёлыг бий болгож байна гэж үзэж ирсэн түүхтэй. Бид одоо ч *пайдейя* /сургах, соёх/ тухайгаа ярьсаар л байгаа: Тэр нь улмаар *педигогика* буюу сурган хүмүүжүүлэх ухаан болж, бүх л бүтэн тогтолцооны тухай ярьдаг, судалж, ажил хэрэг болгодог болсон. Эрт цагаас эхлэн *арете* буюу сайн үйлстний тухай, төгөлдөржүүлэх тухай ч ярьж, санаа тавьдаг байсныг бид мэднэ. Одоо харин тэр сайн сайхан хүнээ ярихын сацуу орчин цагийн шинэчүүлийн тухай, арестократууд, авилгачдынхаа тухай ярьдаг болсон байна. Авлага гэж авах ёстой юмаа авдаг, түгээдэг соёлыг хэлдэг байсан бол одоо авлига гэдэг авах ёсгүй юмаа авдаг хүмүүсийн тухай ярьдаг болсон байна. Бидний соёл хаашаа явж байна?

Тэр нэгэн цагт *этос* гэж ёсзүйн тухай хүний зан ааш, төлөв, хэвшлийн тухай ярьдаг байсан бол одоо бид зүй бус байдал, ёс бус үйл, түйвээгч, сүйтгэгчдийн тухай ярьдаг болжээ. Хүн маань хаашаа явж байна?

Дээр цагт калогате гэж сайн сайхан, хоо үзэсгэлэнгийн тухай ярьдаг байсан, одоо ч мөн ярьсаар л байгаа ч үүний сацуу уугал сайхныг, төрөлх оршил, хэвшлийг эвдэх, тэр байтугаа төрсөн биеэ өөрчлөх тухай ярьдаг болсон байна. Хүмүүний үзэл бодол, соёлт харилцаа маань хаашаа явж байна?

Бидний мэдэхээр, хүний ухаан нэлээн тэлсэн үед ялангуяа Милетийн сургуулийнхан байгалийн язгуур шинжийн тухай ярьж, бүх юм язгууртаа эгэдэг тухай ухааныг нээж, *фюсис* гэдэг ойлголтыг гаргаж ирсэн байдаг[4].

Бидний мэддэг бүрэлбаатай төстэй ойлголт тэр үед байж л дээ. Дараа нь Аристотель түүний нь аху-н тухай ойлголтоор тэлсэн. Гэтэл байгаль хүний шүтэлцээ, харилцаа холбоо тэс өөр ойлголт руу хэвийж, хүн байгалийн Эзэн! гэдэг номлол руу шилжирснээс хойш бид байгаль эхээ тасралтгүй эрж хайх болсон байна. Бид ч бас байгаль Эхээ эрж хайж эхэллээ. Байгалийн үр сад болсон хүнээ ч эрж хайхад хүрсэн байна! Тиймээс цаашид:

1. Соёл судлалд хүнсудлалыг гол болгох цаг болжээ! Хүн гэдэг хэн бэ? гэдгийг илүү ул суурьтай, язгуур угшилтай ойлгох шаардлага бий болсон байна. Мэдлэг ухааныг чухалчилдаг Өрнө болоод дотоод ухаарал, сэтгэлийг гол болгодог Дорнын үзэл, хандлагуудыг ойртуулан, хүний чинадад нэвтрэх, хүн гэдэг амьтныг өөр нүдээр харах цаг болсон байна.

2. Хүний хийж бүтээж, үйлдээд байгааг юу хийгээд байгаа юм бэ? гэдгийг асуух, анхаарах цаг ирсэн байна. Хүн маань бүтээгч үү, бүрэлгэгч үү? Мөнгө л олж байвал болно гэж боддог нь зөв үү? Олон олон асуулт амьдралаас урган гарч байна.

3. Хүн, нийгмийн оршихуй, бүтээхүйг төдийгүй ертөнцийн явдлыг ойлгох. *Газар, Тэнгэрийн амьсгалыг нийлүүлэх* нь соёл хэмээн үзэх цаг ч ирсэн байгааг анзаарах учиртай[5]. Милетийн дэг сургуулийнхан байгалийн язгуур шинжийн тухай ярьж, бүх юм язгууртаа эгэдэг тухай ойлголтыг бий болгож байсан шиг бид ч бас тэрхүү их орчлын тухай ойлголтыг соёлсудлалын ай савд багтаах цаг болсон гэж үзэлтэй байна. Эдүгээ хүртэл ертөнцийн явдлыг байтугаа хүний явдлыг ч буруу зөрүү ойлгосоор ирсэн нь үнэн юм. Томыг ойлгож байж багыг ойлгох, багыг анзаарч байж ихийг мэдэх нь зайлшгүй! Ухаарваас, одоо болтол хүмүүн төрөлтөн соёлт хүн, соёлт нийгэм бий болгож чадсангүй гэдгийг хүлээн зөвшөөхөд улам бүр ойртож байгаа. Түүгээр ч үл барам, соёлыг бүтээгч хүн маань дэлхий эхтэй, Тэнгэр эцэгтэйгээ умартан өөрийгөө Ертөнцийн Эзэн, эзэрхэгч гэж үздэг болсон нь ч үнэн! Өндөр хөгжил, их бүтээн байгуулалтынхаа ард бид хүнээ гээгдүүлчихсэн байна. Хүнээ гээсэн, Эзэнгүй болгосон болохоор соёл маань хөгжиж биш, хөших, уруудах буруудах тийшээ ханджээ. Соёл судлал үүнийг зайлшгүй анхаарах учиртай!

IV. Дүгнэлт

О.Шпенглерийн псевдоморфоз буюу хуурамч агуулал гэж хөрвүүлэн ойлгож болмоор нэгэн баримтлал, дүгнэлтийг А.Тойнби өндрөөр үнэлж: уулзан золгож, харилцан үйлчлэлцэж буй хоёр иргэншлийн хувьд харилцан адилгүй, нэг нь илүү хүчирхэг, нөгөө нь илүү бүтээлч байх үе тохиолдоно. Ийм тохиолдолд илүү бүтээлч иргэншил нь өнгөндөө арга буюу хүчирхэгдээ харьяалагдаж, тэнэмэл хавч бусдын хясаанд шурган нуугддаг шиг тэрхүү ерөнхий соёлын төрхөд өртөх тал бий. Хэрвээ судлаач ийм байдлын ил харагдаж буйг үнэн мөн гэж ойлговол төөрөгдөлд хүрнэ. Тиймд өнгөн хэсгээс дотогш өнгийж, үндэс язгуурт нь юу оршиж буйг харах хэрэгтэй гэж зөвлөсөн байдаг[6]. Арнольд Тойнби энэ гярхай ажиглалт, ухаалаг, няхуур зөвлөлтөө бидэнд ч мөн хэрэг болно. Юу гэвэл, бид бусдыг даган дууриаж, өөрийгөө алдаж, гээх нь улам бүр нэмэгдсээр л байгаа юм!

Өөрийн соёлтой байхад бусдын соёлыг ойлгох ухаарах, хүлээн авах зузаан хөрс бий болно. Соёлууд бие биенээ хөнөөх биш харилцан үйлчлэлцэж,

шүтэлцэж, баяжиж тэлж, өргөжин хөгжинө. Соёлсудлал ч даган дууриалтаас биш ойлголт ухаарлаас эхлэнэ. Соёл судлалын ойлголт ухааралд нэмэх үг, өдөөлгө болгох санаа ийм байна.

Ашигласан материал

1. Катон М.П. (1950). Земледелие /De agri cultura/ Из-во АН СССР.
2. White Leslie. (1959). The Evolution of culture: The development of Civilization to the Fall of Rome – New York: Mc Grow.
3. Дашням Л. (2003). Хүнлиг соёл иргэншил. Уб., 29-44 дэх тал
4. Лебедев А.В. (2010). Милитская школа (Новая философская энциклопедия) Т.4. Из-во. Мысль.,
5. Дашням Л. (2020). Язгуураа танихуйд өчүүхэн тус. Уб., 295 дахь тал
6. Тойнби А. (1993). Постигение истории. Из-во. Мысль., стр. 670